

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/237/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
Мөрөн сум
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 88090438 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Ахлах аудитор: Л.Отгонбаяр

Цахим хаяг: imfo@bizcon.mn

Ахлах аудитор Ч.Мөнхбаяр

Утас: 99996784 Цахим хаяг: mm.bayar0711@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын дүгнэлт, санал.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт.....	17
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Төлбөрийн акт.....	18
4.3 Албан шаардлага.....	18
4.4 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

67123. Хөвсгөл аймаг. Мөрөн сум, Урандөш баг
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас, факс: 70-38 37-93
Э-мэйл: khuvsgul@audit.gov.mn
Вэбсайт: www.audit.mn

2022.02.24 № 01/442
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН МАЛ
ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ДАРГА
Л.АРИУНАА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХӨА	Хөвсгөл аймаг
НА	Нотлох аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ҮОМШӨ	Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн Хурал
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны сайд
МЭЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УМЭАЦТЛ	Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ХА	Харьцуулалтын арга
МЭҮТ	Мал эмнэлгийн үндэсний төв
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>231,177,051.55</u>	<u>244,639,319.45</u>
33	АВЛАГА	30,604,188.56	30,000,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	604,188.56	-
335	Бусад авлага	30,000,000.00	30,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	30,000,000.00	30,000,000.00
34	УРЬДЧИЛГАА	-	7,200,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	7,200,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	200,572,862.99	207,439,319.45
351	Түүхий эд материал	145,143,293.41	150,234,073.98
35110	Тусгай зориулалттай материал	57,286,459.95	-
35130	Эм боох материал	87,856,833.46	150,234,073.98
354	Хангамжийн материал	48,869,594.58	49,757,295.47
35410	Бичиг хэргийн материал	4,914,770.00	6,610,115.00
35420	Аж ахуйн материал	26,157,894.74	23,725,021.63
35430	Сэлбэг хэрэгсэл	6,618,800.00	5,476,800.00
35440	Түлш, шатах тослох материал	1,724,076.00	4,298,345.00
35450	Барилгын засварын материал	170,000.00	695,960.00
35470	Бусад хангамжийн материал	9,284,053.84	8,951,053.84
35600	Мал амьтад	6,559,975.00	7,447,950.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>638,891,879.72</u>	<u>602,205,965.48</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	638,891,879.72	602,205,965.48
392	Биет хөрөнгө	503,524,879.79	466,838,965.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	76,631,816.60	76,631,816.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	(11,617,578.46)	(14,363,418.58)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	286,675,972.52	286,675,972.52
39204	Хуримтлагдсан элэгдэл	(158,243,710.41)	(190,409,592.21)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	542,160,200.36	576,198,600.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	(257,111,712.57)	(289,033,816.57)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,172,931.00	33,172,931.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,143,039.25)	(12,033,527.57)
393	Биет бус хөрөнгө	135,366,999.93	135,366,999.93
39301	Программ хангамж	2,280,000.00	2,280,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(373,000.07)	(373,000.07)
39303	Бусад биет бус хөрөнгө	133,460,000.00	133,460,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	<u>870,068,931.27</u>	<u>846,845,284.93</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>(0.00)</u>	<u>793,524.58</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	(0.00)	793,524.58
413	Өглөг	(0.00)	793,524.58

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	258,874.58
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	43,000.00
4136	Бусад өглөг	(0.00)	491,650.00
41361	Байгууллагад төлөх өглөг	(0.00)	491,650.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	870,068,931.27	846,051,760.35
51	Засгийн газрын хувь оролцоо	870,068,931.27	846,051,760.35
512	Хуримтлагдсан үр дүн	870,068,931.27	846,051,760.35
51210	Өмнөх үеийн үр дүн	701,610,283.12	870,068,931.27
51220	Тайлант үеийн үр дүн	168,458,648.15	(24,017,170.92)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	870,068,931.27	846,845,284.93

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2,629,142,771.58	2,562,862,150.99
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	676,533,336.58	486,212,053.99
120	Нийтлэг татварын бус орлого	676,533,336.58	486,212,053.99
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	676,533,336.58	486,212,053.99
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,322,090.00	2,002,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	674,211,246.58	484,209,553.99
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,952,609,435.00	2,076,650,097.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	902,381,800.00	1,213,809,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	902,381,800.00	1,213,809,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,050,227,635.00	862,840,297.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	584,845,700.00	751,287,737.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	462,281,820.00	65,024,080.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,100,115.00	46,528,480.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,460,684,123.43	2,586,879,321.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,460,684,123.43	2,586,879,321.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,425,312,455.36	2,516,565,115.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	111,048,800.00	720,641,488.56

210101	Үндсэн цалин	80,444,400.00	557,565,555.59
210102	Нэмэгдэл	27,034,400.00	139,826,832.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,570,000.00	23,249,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,991,500.00	93,335,000.00
210201	Тэтгэврийн даатгал	10,549,600.00	65,681,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,110,500.00	6,913,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	888,300.00	5,530,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	222,100.00	1,382,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,221,000.00	13,827,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,456,098.57	24,711,135.94
210301	Гэрэл, цахилгаан	2,854,898.57	2,825,135.94
210302	Түлш, халаалт	19,130,400.00	21,038,000.00
210303	Цэвэр, бохир ус	470,800.00	848,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	63,490,060.72	54,801,425.41
210401	Бичиг хэрэг	9,788,588.00	8,712,595.00
210402	Тээвэр, шатахуун	35,375,085.40	34,366,810.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,568,372.96	6,108,497.30
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	97,800.00	75,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,819,278.66	5,538,123.11
210408	Бараа материал акталсны зардал	8,840,935.70	-
2105	Нормативт зардал	654,787,074.67	594,586,414.47
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	653,836,324.67	591,778,414.47
210502	Хоол, хүнс	950,750.00	2,808,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,558,900.00	5,906,400.00
210604	Урсгал засвар	6,558,900.00	5,906,400.00
2107	Томилолт, зочны зардал	12,393,500.00	27,077,300.00
210702	Дотоод албан томилолт	12,393,500.00	27,077,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,461,606,117.74	855,943,429.58

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,459,748,317.74	849,277,729.58
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	205,000.00	1,200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	806,300.00	548,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	284,100.00	227,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	162,400.00	129,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	4,560,000.00
210807	Газрын төлбөр	-	300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	77,980,403.66	139,562,521.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,606,323.16	68,838,206.95
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	61,374,080.50	70,724,314.24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,371,668.07	70,314,206.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,908,200.00	65,986,092.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	1,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,010,000.00	61,914,192.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	898,200.00	3,071,900.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,463,468.07	4,328,114.76
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,463,468.07	4,328,114.76
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	<u>168,458,648.15</u>	<u>(24,017,170.92)</u>
5	НИЙТ ҮР ДҮН	<u>168,458,648.15</u>	<u>(24,017,170.92)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	701,610,283.12	701,610,283.12
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	701,610,283.12	701,610,283.12
C07	Тайлант үеийн үр дүн	168,458,648.15	168,458,648.15
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	870,068,931.27	870,068,931.27
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	870,068,931.27	870,068,931.27
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	870,068,931.27	870,068,931.27
D08	Тайлант үеийн үр дүн	<u>-24,017,170.92</u>	<u>-24,017,170.92</u>
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	846,051,760.35	846,051,760.35

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	<u>1,954,931,525.00</u>	<u>2,078,652,597.00</u>
12	Татварын бус орлого	2,322,090.00	2,002,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,322,090.00	2,002,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,322,090.00	2,002,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,322,090.00	2,002,500.00
13	Тусламж, санхүүжилтийн орлого	1,952,609,435.00	2,076,650,097.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	902,381,800.00	1,213,809,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	902,381,800.00	1,213,809,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,050,227,635.00	862,840,297.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	584,845,700.00	751,287,737.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	462,281,820.00	65,024,080.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,100,115.00	46,528,480.00
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	<u>1,939,498,410.00</u>	<u>2,044,614,197.00</u>
21	Урсгал зардал	1,939,498,410.00	2,044,614,197.00
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	1,904,126,741.93	1,974,299,990.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	111,048,800.00	720,037,300.00
210101	Үндсэн цалин	80,444,400.00	557,088,169.40
210102	Нэмэгдэл	27,034,400.00	139,700,030.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,570,000.00	23,249,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,991,500.00	93,335,800.00
210201	Тэтгэврийн даатгал	10,549,600.00	65,680,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,110,500.00	6,913,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	888,300.00	5,531,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	222,100.00	1,382,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,221,000.00	13,827,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,456,098.57	24,271,135.94
210301	Гэрэл, цахилгаан	2,854,898.57	2,825,135.94
210302	Түлш, халаалт	19,130,400.00	21,038,000.00
210303	Цэвэр, бохир ус	470,800.00	408,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	57,082,832.96	52,436,166.30

210401	Бичиг хэрэг	12,105,800.00	10,886,290.00
210402	Тээвэр, шатахуун	35,721,660.00	34,941,079.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,568,372.96	6,108,497.30
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	97,800.00	75,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,589,200.00	424,900.00
2105	Нормативт зардал	174,656,380.00	175,285,343.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	172,719,230.00	172,293,643.00
210502	Хоол, хүнс	-	2,814,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,937,150.00	177,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,417,900.00	7,297,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	420,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,350,000.00	-
210604	Урсгал засвар	42,647,900.00	7,297,300.00
2107	Томилолт, зочны зардал	12,393,500.00	27,077,300.00
210702	Дотоод албан томилолт	12,393,500.00	27,077,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,464,079,730.40	874,559,645.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,462,221,930.40	860,693,945.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	205,000.00	1,200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	806,300.00	548,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	284,100.00	227,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	162,400.00	129,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	11,760,000.00
210807	Газрын төлбөр	-	300.00
213	Урсгал шилжүүлэг	35,371,668.07	70,314,206.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,908,200.00	65,986,092.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	1,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,010,000.00	61,914,192.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	898,200.00	3,071,900.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,463,468.07	4,328,114.76
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,463,468.07	4,328,114.76
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	15,433,115.00	34,038,400.00
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дун	15,433,115.00	34,038,400.00
22	Хөрөнгийн зардал	15,433,115.00	34,038,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	15,433,115.00	34,038,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,433,115.00	34,038,400.00

6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(15,433,115.00)	(34,038,400.00)
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан			
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,215,812,300.00	1,211,514,925.24
21	Урсгал зардал	1,213,809,800.00	1,211,514,925.24
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	1,149,070,200.00	1,147,882,133.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	720,037,300.00	720,037,300.00
210101	Үндсэн цалин	556,207,500.00	557,088,169.40
210102	Нэмэгдэл	140,580,700.00	139,700,030.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,249,100.00	23,249,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,335,800.00	93,335,800.00
210201	Тэтгэврийн даатгал	65,680,700.00	65,680,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,913,800.00	6,913,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,531,000.00	5,531,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,382,800.00	1,382,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,827,500.00	13,827,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,925,100.00	21,802,135.94
210301	Гэрэл, цахилгаан	2,948,100.00	2,825,135.94
210302	Түлш, халаалт	18,569,000.00	18,569,000.00
210303	Цэвэр, бохир ус	408,000.00	408,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,309,300.00	24,257,297.30
210401	Бичиг хэрэг	7,164,900.00	7,164,900.00
210402	Тээвэр, шатахуун	12,126,000.00	12,126,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,471,500.00	4,568,497.30
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	224,400.00	75,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	322,500.00	322,500.00
2105	Нормативт зардал	10,594,600.00	10,594,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,417,400.00	10,417,400.00
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	177,200.00	177,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,957,800.00	2,949,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,740,800.00	1,740,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-
210604	Урсгал засвар	1,217,000.00	1,209,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,141,300.00	4,141,300.00
210702	Дотоод албан томилолт	4,141,300.00	4,141,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	270,769,000.00	270,763,900.00

Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	256,903,300.00	256,898,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,200,000.00	1,200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	548,200.00	548,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,300.00	227,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	129,900.00	129,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,760,000.00	11,760,000.00
210807	Газрын төлбөр	300.00	300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	64,739,600.00	63,632,792.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	63,021,000.00	61,914,192.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	718,600.00	718,600.00
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,215,812,300.00	1,211,514,925.24
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,002,500.00	2,002,500.00
122005	төсвөөс	1,213,809,800.00	1,209,712,425.24
62	Ажиллагсдын тоо	63	60
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	49	46
620003	Үйлчлэх ажилтан	13	13

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	862,840,297.00
21	Урсгал зардал	862,840,297.00
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	860,456,257.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,469,000.00
210302	Түлш, халаалт	2,469,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,876,469.00
210401	Бичиг хэрэг	3,721,390.00
210402	Тээвэр, шатахуун	22,815,079.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,540,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,800,000.00
2105	Нормативт зардал	164,690,743.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	161,876,243.00
210502	Хоол, хүнс	2,814,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,688,300.00

Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	28,600,000.00
210604	Урсгал засвар	6,088,300.00
2107	Томилолт, зочны зардал	22,936,000.00
210702	Дотоод албан томилолт	22,936,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	603,795,745.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	603,795,745.00
213	Урсгал шилжүүлэг	2,384,040.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,353,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,353,300.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	30,740.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	30,740.00
II	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	862,840,297.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	862,840,297.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	751,287,737.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	65,024,080.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	46,528,480.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд авлага, өглөг, зардлын данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд: Засгийн Газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”-ыг хэрэгжүүлэх, “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хүснэгтийн Тэтгэврийн даатгал-Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний “9.5” гэснийг “8.5” гэж, Тэтгэврийн даатгал-Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний “9.5” гэснийг “8.5” гэж, Шимтгэлийн дүн-Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний “12.7” гэснийг “11.7” гэж, Шимтгэлийн дүн-Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний “12.5” гэснийг “11.5” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “12.5 хувиас” гэснийг “11.5 хувиас” гэж тус тус өөрчилсүгэй” гэж заасныг хэрэгжүүлж ажилласан байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өглөг, авлага болон зардлын данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Бизкон Аудит ХХК-ийн Хөвсгөл салбарын ахлах аудитор Л.Отгонбаяр, аудитор Ч.Мөнхбаяр нар гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Бизкон Аудит ХХК-ийн Хөвсгөл салбарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газар нь мал эмнэлгийн мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдлыг баталгаажуулах, аймгийн хэмжээний мал эмнэлгийн төр, хувийн хэвшлийн байгууллагыг нэгдсэн бодлогоор ханган, нийтийн эрүүл мэндийг хамгаалахад оршино хэмээн тодорхойлсон байна.

Аймгийн Мал эмнэлгийн салбарын чиг үүрэг: Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд салбарын бодлого чиглэл, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах, мал, амьтны өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, тандах, оношлох, мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангах,

баталгаажуулах замаар нийтийн эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлгийн ажил үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангуулах, салбарын ажиллагсдыг нэгдсэн удирдлагаар хангаж, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий ХХААХҮЯ-ны харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон бөгөөд Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг шинэчлэн баталсныг мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна. Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газар нь МУ-ын ХХААХҮС-ын 2019 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А-385 тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагад тайлант онд хөндлөнгийн хяналт шалгалт хийгдээгүй бөгөөд байгууллагын дотоод хяналтын талаар хангалттай судалсны үндсэн дээр дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны 3 дугаар улирлын байдлаарх үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 3 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн болох 1,500.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 30.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 24.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Учир нь тайлант оны эхний 3 улирлын байдлаарх тоон үзүүлэлтээр суурь үзүүлэлтийг тооцсон тул жилийн эцсийн байдлаарх тоон үзүүлэлтээр шинэчлэн тогтоох нь зохимжтой гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газар нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23.2 сая төгрөгөөр буюу 2.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	30.6	30.0	-0.6
Урьдчилгаа		7.2	7.2
Бараа материал	200.6	207.4	6.8
Үндсэн хөрөнгө	638.8	602.2	-36.6
Нийт хөрөнгө	870.0	846.8	-23.2
Өр төлбөр		0.8	0.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	870.0	846.0	-24.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	870.0	846.8	-23.2

Авлага дансны үлдэгдэл 6.0 сая төгрөгөөр буурч тайлант оны эцсийн үлдэгдэл 30.0 сая төгрөг байна. Энэ нь “Хөдөө аж ахуй хөгжлийн тулгуур” дэд хөтөлбөрийн “Монгол мал” хөтөлбөрийн хүрээнд Швейцарын хөгжлийн агентлагийн хөрөнгөөр мал эмнэлгийн барилга шинээр барьж тайлан онд МЭЕГ-аас болон аймгийн ОНӨГ-ын холбогдох албан тушаалтнууд хүлээн авсан боловч ТӨБЗГ-ас шийдвэр ирээгүй учраас барилгыг хүлээн авч орлогод бүртгээгүйгээс шалтгаалж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 207.4 сая төгрөг болж 6.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийт төсвийн хөрөнгөөр 233.5 сая төгрөгийн бараа материал худалдан авсан, тусгай зориулалтын данснаас 49.0 сая төгрөгийн бараа материалыг эм боох материал дансанд шилжүүлэн бүртгэсэн. Улсын төсвийн хөрөнгөөр МЭЕГ, УМЭАЦТЛ, Биокомбинат УТҮГ-аас тусгай зориулалттай материал 0.03 сая төгрөг, эм ороох боох материал 427.7 сая төгрөг, 7.5 сая төгрөгийн мал амьтад нийт 435.2 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй орлогод бүртгэсэн байна. Мөн нийт 710.9 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 602.2 сая төгрөг болж 36.6 сая төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансанд 34.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан байна. Үүнд: Швейцарын хөгжлийн агентлагийн хөрөнгөөр МЭТ, МЭҮН-үүд болон МЭГ-ын албан хаагчдад ТАВ А-7 24 ш, хэвлэгч 24 ш, нөтбүүк 1, сүү шинжлэгч багаж 1 ш нийт 29,1 сая төгрөгийн хөрөнгө авсан байна. Урсгал зардлаас 4.9 сая төгрөгийн компьютер, принтерийг худалдан авсан байна.

Биет бус хөрөнгө дансны үлдэгдэл 135.3 сая төгрөг байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 0.8 сая төгрөг байна. Үүнд: НДШ өглөг 0.3 сая төгрөг, “Хөвсгөл ус суваг” ХХК-д 0.5 сая төгрөгийн өглөгийг тус тус бүртгэж тайлагнасан байна.

Мал эмнэлгийн газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 66.6 сая төгрөгөөр буюу 2.5 хувиар буурсан байна. Тайлант онд үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө ирээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитаар онцлох асуудалтай зүйл байхгүй байна.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага:

- Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.
- Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

3.8 Аудитын гол асуудал

Засгийн Газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”-ыг тогтоолыг хэрэгжүүлж гэрэл цахилгааны зардлаас 0.1 сая төгрөг, шуудан холбооны зардлаас 0.9 сая төгрөг, хог хаягдал материалын зардлаас 0.1 сая төгрөг, урсгал засвар зардлаас 0.008 сая төгрөг бараа үйлчилгээний зардлаас 0.005 сая төгрөг, өөрийн орлогоос 2.0 сая төгрөг нийт 3.2 сая төгрөгийн төсөв хэмнэсэн байна.

7.2 сая төгрөгийн зардлыг урьдчилж гарсан зардалд бүртгэсэн нь: Тус газрын НБББББ-ийн /5.2 авлага ба урьдчилгаа тооцооны бүртгэл/-тэй нийцэж байгаа хэдий ч тайлант оны зардал биш байна. Программ хангамжийн түрээсийн зардлыг урьдчилж төлсөн гэж тайлагнасан хэдий ч тайлангийн тодруулгад тодорхой толилуулаагүй, Санхүүгийн программ хангамжийн тооцоолох төвтэй хийсэн гэрээнд урьдчилгаа төлбөрийн талаар тусгаагүй байна. Иймд: Тайлант оны зардал биш бөгөөд ЗГ-ын 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 1.1. /үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах;/-тай нийцэхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг авч үзэхэд www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлбэл зохих 1,323.8 сая төгрөгийн /давхардсан тоогоор/ 151 мэдээллээс 1,323.8 сая төгрөгийн 147 мэдээллийг байршуулсан, үүнээс (Хуулийн 6.4.5

6.4.8 заалтын хүрээнд) хүрээнд байршуулах 50.1 сая төгрөгийн 7 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Аудитын явцад (Хуулийн 6.4.5 6.4.8 заалтын хүрээнд) мэдээлэх 7 мэдээллийг нэмж байршуулсан байна. Хугацаа болоогүй 4 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль, МУ-ын ЗГ-ын 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 124 дүгээр Босго шинэчлэн батлах тухай” тогтоолын дагуу 322.8 сая төгрөгийн 32 удаагийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажилласан бөгөөд 4 худалдан авах ажиллагааг ХА-аар цахимаар зохион байгуулж ажилласан байна. Худалдан авах үйл ажиллагаатай холбоотой ямар нэгэн санал гомдол, маргаантай асуудал гараагүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын Хавсралт 2 (Хуулийн 6.1.1, 6.1.6, 6.3.1, 6.2.2, 6.2.3, 6.2.6, 6.3.3 заалтын хүрээнд), мөн журмын Хавсралт 9 (Хуулийн 6.4.5 заалтын хүрээнд) заасан мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, иж бүрэн мэдээлж байх гэсэн 1 зөвлөмж хүргүүлснийг 80 % - тай хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардлаас гэрээт аж ахуйн нэгж болох мал эмнэлгийн нэгжүүдэд тайлант онд 849.3 сая төгрөгийн үйлчилгээний хөлс олгосон байна. Энэхүү үйлчилгээний хөлс олголтод дотоод хяналт шалгалт хийгдээгүй, тус аж ахуйн нэгжийг мал эмнэлгээс олгосон үйлчилгээний хөлсийг зориулалтын дагуу зарцуулсан гэх нотлох баримт/тухайн аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан/ байхгүй байна. Зөвхөн мал эмнэлгийн улсын байцаагчийн хяналтын баримт бичиг байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2. батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих; заалттай нийцэхгүй байна. Иймд: энэхүү асуудлыг дараагийн аудитаар анхаарч үзэх зүйтэй гэж үзэв.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 95.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 49.0 сая төгрөгийн алдааг залруулж, 46.5 сая төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

2020 онд үүссэн 30.0 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, тайлант онд 0.8 сая төгрөгийн өглөг үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэсэн заалттай нийцэхгүй байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 2.0 сая төгрөгийн шатахуун зарцуулсан, Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардлаас эдийн засгийн ангилал зөрчиж 3.6 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж бэлтгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; гэсэн заалттай нийцэхгүй байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардлаас гэрээт аж ахуйн нэгж болох мал эмнэлгийн нэгжүүдэд тайлант онд 849.3 сая төгрөгийн үйлчилгээний хөлс олгосон байна. Энэхүү үйлчилгээний хөлс олголтод дотоод хяналт шалгалт хийгдээгүй, тус аж ахуйн нэгжийг мал эмнэлгээс олгосон үйлчилгээний хөлсийг зориулалтын дагуу

зарцуулсан гэх нотлох баримт/тухайн аж ахуйн нэгжийн тайлан/ байхгүй байна. Зөвхөн мал эмнэлгийн улсын байцаагчийн хяналтын баримт бичиг байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2.батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих; заалттай нийцэхгүй байна.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 49.0 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн алдаа илэрснийг аудитын хугацаанд залруулсан болно.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага тогтоогдоогүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлага, өглөгтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

2020 онд үүссэн 30.0 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, тайлант онд 0.8 сая төгрөгийн өглөг үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх. 16 дугаар зүйлийн 16.5.4.төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, 16 дугаар зүйлийн 16.5.4.төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 2.0 сая төгрөгийн шатахуун, ороох боох материалын зардалд 10.1 сая төгрөг тус тус зарцуулсан, Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардлаас эдийн засгийн ангилал зөрчиж 3.6 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж бэлтгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; заалтыг хэрэгжүүлж ажиллах

3. Зардлын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардлаас гэрээт аж ахуйн нэгж болох мал эмнэлгийн нэгжүүдэд тайлант онд 849.3 сая төгрөгийн үйлчилгээний хөлс олгосон байна. Энэхүү үйлчилгээний хөлс олголтод дотоод хяналт шалгалт хийгдээгүй, тус аж ахуйн нэгжийг мал эмнэлгээс олгосон үйлчилгээний хөлсийг зориулалтын дагуу зарцуулсан гэх нотлох баримт/тухайн аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан/ байхгүй байна. Зөвхөн мал эмнэлгийн улсын байцаагчийн хяналтын баримт бичиг байна. Энэ нь Төсвийн

тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2. батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих; заалттай нийцэхгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардлаас гэрээт аж ахуйн нэгж болох мал эмнэлгийн нэгжүүдэд үйлчилгээний хөлс олгоходоо тухайн аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайланг аудитын байгууллагаар баталгаажуулсны үндсэн дээр олгох бөгөөд гэрээг үйл ажиллагааны онцлогт тохируулан хийх, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2. батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих; заалтыг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газар	4	95.5	1	49.0					3	46.5